



ДУНДГОВЬ АЙМАГ
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 11 өдөр

Дугаар 8/05

Хажуу шинэ ус

Г Зохион байгуулалтын арга хэмжээ Т

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, аймгийн засаг даргын А/10 тоот захирамж, Сумын онцгой комиссын 01 дүгээр хуралдааныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын хэмжээнд 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдрийг дуустал хугацаанд олон нийтийг хамарсан уралдаан тэмцээн, соёлын арга хэмжээг хориглож хяналт тавьж ажиллахыг Хэсгийн төлөлөгч (Э.Ванчиндорж)-д үүрэг болгосугай.

2. Сар шинийн баярыг тохиолдуулан нийтийг хамарсан золголтыг хориглож, түүнд хяналт тавьж ажиллахыг бүх аж ахуй нэгж, байгууллагын дарга эрхлэгч, хэсгийн төлөөлөгч нарт үүрэг болгосугай.

3. Хурал цуглаан хийхэд 50 хувийн дүүргэлттэйгээр корона вирусын халдварт (КОВИД-19)-ын эсрэг дархлаажуулалтын 3,4 дүгээр тунгийн хамрагдалт, корона вирусын халдвартын шинжилгээний хариуг харгалзан халдварт хамгааллын дэглэмийг баримтлан зохион байгуулахыг зөвшөөрсүгэй.

4. Сар шинийн баярыг гэр бүлийн хэмжээнд тэмдэглэж, корона вирусын халдварт (КОВИД-19)-ын эсрэг дархлаажуулалтанд идэвхтэй хамрагдаж, халдвараас урьдчилан сэргийлэхийг нийт иргэдэд уриалсугай.

5. Насанд хүрээгүй хүүхэд, багачуудыг үйлчилгээний байгууллага, дэлгүүрээр явуулахгүй байхыг нийт эцэг эхчүүдэд үүрэгжүүлсүгэй.

6. Корона вирусын дэгдэлт нэмэгдсэнтэй холбогдуулж халдварт хамгааллын дэглэмийг сайжруулах, иргэд хоорондын зайлт бариулах, маскүй иргэдэд үйлчилгэхгүй байхыг ААН, үйлчилгээний байгууллагуудын дарга, эрхлэгч (Угтаал чандмань хоршоо Д.Амгалан, Угтаал трэйд ХХК Л.Өлзийбүрэн, Дэлгэр хонгор ХХК М.Эрдэнэбат, Хараат хүнсний дэлгүүр Д.Долгоржав, Хамтын хүч хүнсний дэлгүүр Л.Дамбадүгэр, ХААН банк Э.Түмэндэлгэр, Төрийн банк М.Нямдорж) нарт үүрэг болгосугай.

7. Захирамжийн хэрэжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Д.Сарангэрэл)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ө.МӨНХ-АМГАЛАН